



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.7, Дотоод аудитын хорооны 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй талаар тодорхой арга хэмжээ авч, төлөвлөгөө гарган, байнгын хяналт тавьж ажиллахын хамт дараах асуудлыг анхаарч ажиллахыг зөвлөж байна.

1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний байгууллага, хуулийн этгээдийн төсөв захирагч нарт:

- Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг үнэн зөв, бодитой, иж бүрэн, тогтоосон хугацаанд тогтмол мэдээлдэг байхыг;
- Шилэн дансны тухай хууль, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг;

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга М.Энхболдод:

- Зам, тээврийн хөгжлийн яамны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг улирал бүр хянаж, дүнг дараа улирлын эхний сарын 15-ны дотор Сайдад танилцуулж байхыг тус тус даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар / М.Энхболд/-т үүрэг болгосугай.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД,
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА  Л.ХАЛТАР

